



# WHITE PAPER 2.0



## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Капекс виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн олон нийтэд санал болгосон CPX виртуал хөрөнгөтэй холбоотой дараах эрсдэлүүд учирч болохыг анхаарна уу. Үүнд:

- Виртуал хөрөнгө нь хууль ёсны мөнгөн тэмдэгтэд хамаарахгүй, эсхүл Төв банк эсхүл Засгийн газраас баталгаажихгүй;
- Виртуал хөрөнгө нь хадгаламжийн даатгал, үнэт цаасны хөрөнгө оруулагчдыг хамгаалах аливаа даатгалд хамаардаггүй;
- Виртуал хөрөнгийн гүйлгээ нь гүйлгээ хийгдсэн хугацаанаас үл хамааран бүртгэлийн системд бүртгэгдсэн хугацаагаар гүйлгээ хийгдсэнд тооцогдоно;
- Виртуал хөрөнгийн талаарх олон улсын хэм хэмжээ, дотоодын хууль тогтоомжоос хамаарч виртуал хөрөнгийн үйлчилгээ болон үнэ цэнэ огцом өөрчлөгдөх эрсдэлтэй;
- Виртуал хөрөнгийн гүйлгээ нь буцаах боломжгүй, залилан мэхлэх шинжтэй, эсхүл алдаатай гүйлгээнээс үүдэн гарах үр дагавар, нөхөн төлөгдөхгүй байх эрсдэлтэй;
- Виртуал хөрөнгийн үнэ цэнэ нь зах зээлд оролцогчдын эрэлт хэрэгцээгээр тодорхойлогдох тул үнэ цэнийн хэлбэлзлээс хамаарч алдагдал хүлээх эрсдэлтэй;
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид технологийн хүндрэл гарсан тохиолдолд харилцагч өөрийн виртуал хөрөнгийг ашиглах, хэрэглэх боломжгүй болох эрсдэлтэй;
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн өмчилж, эсхүл эзэмшиж байгаа хөрөнгө нь харилцагчид учирсан хохирлыг бүрэн барагдуулж хүрэлцэхгүй байх эрсдэлтэй;

Энэхүү виртуал хөрөнгийн танилцуулгад хөрөнгө оруулагч Танд тус виртуал хөрөнгийг худалдан авах шийдвэр гаргахад туслах бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Танилцуулгад хөрөнгө оруулагчид шаардлагатай мэдээллийг бүрэн оруулаагүй байж болох ба лавлах зүйл гарвал биржийн холбогдох дугаарт хандана уу.



# КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

## Нэр

Капекс Капитал ХХК

## Хугацаа

2021 оны 12 сар

## Компанийн хэлбэр

Хязгаарлагдмал хариуцлагатай  
компани

## Холбоо барих

Утас: 75077272


Имэйл: info@capexcapital.mn


## Үйл ажиллагаа

- Виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих
- Виртуал хөрөнгийг шилжүүлэх
- Виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах

## Хаяг

Монгол улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,  
Д.Сүхбаатарын талбай-2,  
Сэнтрал Тауэр, 7 давхар, 707 тоот





## САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Анх 2008 онд блокчэйн технологийг уламжлалт мөнгөн тэмдэгттэй холбоотой үндсэн асуудлыг шийдвэрлэх зорилгоор олон нийтэд танилцуулж байсан түүхтэй. Энэхүү технологийг хэрэглээнд нэвтрүүлснээр дэлхийн эдийн засаг, бизнес, санхүүгийн салбарт төлбөр тооцооны системийн хөгжлийг дараагийн шатанд авчирсан бөгөөд дэлхийн хөрөнгө оруулагч, хэрэглэгчдэд өөрсдийн хөрөнгийг виртуал орчинд төвлөрсөн бус, аюулгүй найдвартай, хөрвөх чадвар сайтай, инфляцаас хараат бус, түргэн шуурхай хугацаанд үнэ цэнийг бүтээх боломжийг олгож чадсан билээ.


Улмаар дэлхий дахинаа виртуал хөрөнгө, түүний хэрэглээ, крипто салбарт хөрөнгө оруулах ойлголт даяаршиж хэрэглэгчдийн эрэлт улам өссөөр 2021 оны эцэст салбарын зах зээлийн үнэлгээ \$2.9 их наяд хүрч түүхэн үзүүлэлтэд хүрсэн. Харин 2022 он бүхэлдээ крипто салбарын томоохон төслүүд бүх цаг үеийн дээд амжилтаасаа ухарсан, олонд хэдийнээ танигдаж салбарын нүүр царай гэгдээд байсан Celsius, Voyager, FTX зэрэг төслүүдийн дампуурал нь виртуал хөрөнгийн үйл ажиллагаа үзүүлэгчид болон виртуал хөрөнгө гаргагч нарт ихээхэн сорилтыг авчирч хөрөнгө оруулагчдын итгэлийг сулруулж, бодлого боловсруулагчид, хэвлэл мэдээлэл, олон нийтийн зүгээс виртуал хөрөнгийн орон зайд хяналт шалгалтыг эрчимжүүлээд байна.

Бидний хувьд Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд, шинэ үеийн залуусын боловсрол, амьдралын хэв маяг, орчин нөхцөлийг сайжруулах бүхий л боломжийг тэгш хүртээх эрхэм зорилгынхоо хүрээнд өөрсдийн нөөц бололцоог ашиглан бидэнд итгэж хөрөнгө оруулсан токен эзэмшигчдийнхээ эрх ашгийг нэн тэргүүнд тавьж салбартаа эзлэх байр суурь, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, харилцагч нартаа амласан амлалт, биржийн хөгжлийн зураглалын дагуу виртуал хөрөнгийн чиглэлээр олон улсын стандарт, сайн туршлагад суурилсан илүү мэргэжлийн түвшний дараах шинэлэг үйлчилгээнүүдийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.



# ЗОРИЛГО

“Санхүүгийн зах зээл дээрх хэрэглэгч”-нийлүүлэгчийн харилцан үр ашгийг орчин үеийн платформ бүхий мэргэшсэн хамт олны үйлчилгээгээр сайжруулж, салбарын хөгжлийг түүчээлнэ.



## ҮНЭТ ЗҮЙЛС



### Хэрэглэгч төвтэй

Бид хэрэглэгчдийнхээ эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, урт хугацааны хамтын ажиллагааг эрхэмлэн, технологийн дэвшлийг харилцагчдадаа тэгш хүртээсэн хэрэглэгч төвтэй үйл ажиллагаа явуулна.



### Хялбар

Бидний санал болгож буй бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээг нэг дороос цогц хэлбэрээр авах боломжтой, ашиглахад хялбар байна.



### Хурдан

Харилцагчдынхаа хүлээлтээс давсан, найдвартай, олон улсын стандартуудад нийцсэн дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд хурдтайгаар байнга хүргэж ажиллахыг эрхэмлэнэ.




### Хариуцлагатай

Бид ямагт хариуцлага, бизнесийн ёс зүйг эрхэмлэн, харилцагч болон салбарын нэр хүнд, эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ажиллана.

# CAPEX.MN БИРЖ

Биржийн систем нь АНУ-д төвтэй, дэлхийн шилдэг хөрөнгийн биржүүд, үндэстэн дамнасан банк, санхүүгийн корпорацуудын ашигладаг Modulus биржийн систем дээр суурилсан. Энэхүү систем нь олон улсын санхүүгийн зохицуулагч байгууллагуудын комплаенс стандартуудыг бүрэн хангасан ба мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, санхүүгийн гэмт хэрэг болон луйврын зориулалттай хуурмаг гүйлгээнүүдээс урьдчилан сэргийлэх цогц горимтой.



Сарех виртуал хөрөнгийн бирж нь Даталанд Технологи ХХК-ийн охин компани статустайгаар 2021 оны 12 сард үүсгэн байгуулагдсан ба олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төвлөрсөн биржийн шийдэл бүхий Modulus системийг Монгол улсад анх удаа онцгой эрхтэйгээр авч виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд амжилттай нэвтрүүлсэн. Монгол улс дах Кripto салбарын эрх зүйн орчинд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль 2022 оны 2 сарын 25-ны өдрөөс мөрдөгдөж эхэлснээр СЗХ-ноос ВХҮҮ-ийн тусгай зөвшөөрлийг албан ёсоор олгож эхэлсэн билээ. Бирж нь СЗХ-ны 2022 оны 11 сарын 25-ны өдрийн №654 тоот тушаалын дагуу тусгай зөвшөөрөл авч, ВХҮҮ-ийн тухай хуулийн дагуу үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧООН

**2021-12**

Олон нийтэд нээлттэй IEO хийн биржийн үндсэн токен болох CPX-ээр нийт ₮3.9 тэрбум татан төвлөрүүлсэн.

**2022-02**

Марс нислэг, Марс марафон, Tether game зэрэг арилжааны идэвхийг нэмэгдүүлэх урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

**2022-04**

Aquanow, B2Broker, Binance-н Liquidity Provider-тай хамтран ажиллах гэрээг байгуулсан.



**2021-12**

Компани үүсгэн байгуулагдсан.



**2022-01**

Дотоодын төслүүдийг дэмжих зорилгоор биржээр дамжуулж дотоодын токены анхдагч, хоёрдогч арилжааг зохион байгуулсан.



**2022-03**

Нийт 10 гаруй шинэ алткойн (altcoin)-г биржид бүртгэж, стэйкинг үйлчилгээг нэвтрүүлсэн.



**2022-05**

Мобайл аппликейшны эхний хувилбарыг хэрэглээнд нэвтрүүлсэн.





**2022-06**

Нийт 461 хэрэглэгчдээс 7.6 тэрбум ширхэг CPX токеныг анхдагч зах зээлийн үнэ болох ₮0.25-өөр эргүүлэн худалдаж авсан.



**2022-07**

Компанийн удирдлага, бүтэц зохион байгуулалт шинэчлэгдсэн.



**2022-08**

Шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээний судалгааг хийж бизнес төлөвлөгөөг өөрчлөн боловсруулсан.



**2022-09**

“Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоо”-ны олон улсын стандартыг бүрэн нэвтрүүлж ISO/IES 27001 сертификат авсан.



**2022-10**

Whitепaper-т тусгасны дагуу нийт 10 сарын хугацаанд орлогын 80% буюу нэгж CPX тутамд нийт ₮0.01-ийн (IEO анхны үнийн 4%, арилжааны дундаж ханшийн 15.3%) ногдол ашгийг хуваарилсан.



**2022-11**

СЗХ-нд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэгдэж үйл ажиллагаа эрхлэх албан ёсны зөвшөөрөл авсан.



**2022-12**

Нийгмийн хариуцлагын хүрээнд виртуал хөрөнгийн салбар дахь нийт хэрэглэгч, хөрөнгө оруулагч нарт тус салбарын суурь мэдлэгийг тогтмол, системтэйгээр хүргэх зорилгоор Capex Academy хөтөлбөрийг эхлүүлэн боловсролын контентыг бэлтгэн нийтэд үнэ төлбөргүй түгээж эхэлсэн.





# ЭРСДЭЛИЙН ХАМГААЛАЛТ

Сарех бирж нь үндсэн үйл ажиллагаандаа олон улсад тэргүүлэгч Modulus системийг ашигладаг ба дараах байдлаар мэдээллийн аюулгүй байдлыг ханган, технологийн эрсдэлийг бууруулан ажиллаж байна.



## Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Modulus биржийн систем нь байнгын нөөцлөлт, засвар үйлчилгээ зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээний тусламжтайгаар системийнхээ тасралтгүй, найдвартай ажиллагааг хангадаг. Мөн тус систем нь таних болон хандалтын удирдлага, 2 давхар баталгаажуулалт, зөвшөөрөлгүй хандалтаас хамгаалах хандалтын хяналт зэрэг функцуудыг өөртөө агуулдаг.

## Эрсдэлийн үнэлгээ

Тус биржийн систем нь үүсэж болзошгүй боломжит доголдол, аюулыг илрүүлэх зорилгоор системийн үнэлгээг тогтмол хийдэг. Үүнд дотоод болон гадаад аюул заналхийлэл, дагаж мөрдөх болон зохицуулалтын хүчин зүйлүүд ордог.



## Эрсдэлийг бууруулах

Дээрх үнэлгээний явцад илэрсэн эрсдэлийг бууруулах арга хэмжээг тухай бүрт авч хэрэгжүүлдэг. Эдгээр арга хэмжээнд аюулгүй байдлын бодлого, протокол, түүнчлэн болзошгүй аюулыг илрүүлж, хариу үйлдэл үзүүлэхэд хяналт тавих, сэрэмжлүүлэх үйлдлийн хөгжүүлэлт зэрэг ордог.



# АЮУЛГҮЙ БАЙДАЛ

## Мэдээллийн аюулгүй байдал

Modulus олон улсын байгууллага нь виртуал хөрөнгийн биржүүдийг хэрэглэгчийн хувийн мэдээлэл, санхүүгийн бүртгэл зэрэг мэдээллийг хадгалах, хамгаалах найдвартай платформоор хангадаг. Тус систем нь нууцийн зэрэглэлтэй мэдээллийг зөвшөөрөлгүй хандалтаас хамгаалах зорилгоор тусгайлсан шифрлэлт болон баталгаажуулалтын протоколуудыг ашигладаг.



## Нууцлал ба аюулгүй байдал

Энэхүү систем нь хэрэглэгчийн мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэхээс хамгаалахын тулд өгөгдлийг шифрлэх, далдлах, мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх зэрэг функцуудыг мөн агуулдаг.





# СИСТЕМИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Modulus биржийн систем нь дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангах дараах хүчин чадалтай.

## Системийн хамгаалалт

- Систем нь өндөр хамгаалалттай бүтээгдсэн.
- Систем нь SQL injection-д өртөхөөргүй.
- DDoS бууруулахад CloudFlare шаардлагатай.
- Офлайн олон гарын үсэг бүхий хүйтэн хэтэвчний системийг ашиглах боломжтой. Нэмэлтээр BitGo санг хадгалах үйлчилгээ.
- Систем нь GDPR болон MiFID II-ийн нийцлийг дэмждэг.
- Тодорхой газарзүйн бүсэд хэрэглэгчид нэвтрэхээс урьдчилан сэргийлэхийн тулд нэмэлт geo-fencing үйлчилгээ ашиглах боломжтой. VPN болон Tor сүлжээг илрүүлэх чадвартай.




## Зах зээлийн эсрэг манипуляци

Манай бодит цагийн зах зээлийн хяналтын систем нь хуурамч, давхардуулах, их хэмжээний арилжаа зэрэг сэжигтэй арилжааны үйлдлийг хянадаг.

## Нягтлан бодох бүртгэл

Нягтлан бодох бүртгэлийн самбар нь бүхий л гараар болон автоматаар орлого хийх, зарлага гаргахыг бүртгэж хянадаг.



## Вэбсайт, аппликейшн

Биржийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тусгайлан бүтээсэн вэб болон орчин үеийн дүр төрхөд нийцүүлсэн нэмэлт мобайл аппликейшн зэрэгт нийцнэ. Уг биржийн систем нь 2 давхар баталгаажуулалт, техник шинжилгээний хэрэгслүүд бүхий графикууд, төрөл бүрийн виртуал хөрөнгө болон түүний мэдээллийн сан зэрэг функцуудыг агуулдаг онцлогтой.



## Админ функц

- Админ самбар нь биржийн төрөл бүрийн статистик мэдээллүүдийг харуулдаг.
- Админ нь виртуал хөрөнгийн нөөцийг тодорхойлох үүднээс төлбөрийн чадварыг нотлох тайлан гаргах боломжтой.
- Админ нь бүх арилжааг зогсоодог “паник унтраах механизм”-д хандах боломжтой.
- Админ тодорхой хэрэглэгчдийг арилжаа хийхийг хориглох боломжтой.
- Админ нь админ хяналтын функцээр дамжуулан виртуал хөрөнгө нэмэх боломжтой.

## Шинэчлэлтүүд

Modulus системээс тодорхойлж, эрэмбэлсэн гол алдааны засваруудыг үнэ төлбөргүй өгдөг.



## Захиалгын төрлүүд

Программ хангамж нь Limit захиалга, Market захиалга, Stop-Limit захиалгыг дэмждэг. Бусад захиалгын төрлүүдийг ирээдүйд нэмэх боломжтой.





## Дэмждэг виртуал хөрөнгүүд

Виртуал хөрөнгүүдийг админы хяналтын функцээр дамжуулан нэмэх боломжтой ба системийг платформд бүрэн нэвтрүүлснээр хэрэглэгчид зөвхөн нэг төрлийн виртуал хөрөнгөөр хязгаарлагдахгүйгээр биржид орлого байршуулах боломжийг олгоно. Орлого байршсаны дараа хэрэглэгчдэд баталгаажуулах автомат имэйл очдог ба хэрэглэгч бүхий л виртуал хөрөнгөд хууль ёсны дагуу шалгалт хийлгэх боломжтой бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Modulus байгууллагад системийн бүртгэлээс хасах хүсэлт илгээх боломжтой байдаг.



## Хүлээн авах, AML, KYC

- Хэрэглэгчийн хүлээн авах систем нь хэрэглэгчдээс KYC мэдээллийг цуглуулдаг. Ингэснээр зөвхөн жинхэнэ хэрэглэгчид бүртгүүлж, үйлчилгээ ашиглахыг зөвшөөрнө.
- Харилцагчаа таниж мэдэх (KYC) баталгаажуулах үйлчилгээ нь нэр, хаяг гэх мэт хэн болохыг, мөн хувийн баримт бичгийн баталгаажуулалт (KYC үйлчилгээнээсээ хамаарч) хийдэг.
- Мөнгө угаахтай тэмцэх (AML) үйлчилгээ нь мөнгө угаах оролдлогыг хянадаг.


## Хөгжүүлэгчийн дэмжлэг

Баримтжуулсан хөгжүүлэгчийн API хангагдсан.



## Дэмждэг блокчэйнүүд

Bitcoin, Bitcoin Forks, Ethereum, ERC20 Tokens, Ethereum Forks, Ethereum Forks Tokens, Omni Tokens, Ripple болон Ripple Assets, Stellar болон Stellar Assets, Waves Blockchain, Waves Forks. Кастодиал хэтэвч: Bitgo болон Fireblocks. Нэмэлт блокчэйн нэмэгдэх боломжтой.



## Даяаршил

Вэб болон гар утасны аппликейшн нь олон хэлний сонголттой.

## Өндөр хүчин чадалтай хөдөлгүүр

- Хэрэглэгчийн сервер дээр байршуулж, засвар үйлчилгээ хийдэг.
- Тохирох хөдөлгүүр нь тохиргоо, техник хангамж зэргээс хамааран секундэд 84 сая хүртэлх гүйлгээг хийх чадалтай.
- Арилжааны өмнөх эрсдэлийн удирдлага нь хэрэглэгчдэд арилжаа хийх хангалттай хөрөнгө байгаа эсэх зэргийг баталгаажуулдаг.





## Хөрвөх чадвар ба market making

Хөрвөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд биржийг гадны хөрвөх чадвар хангах газруудтай холбож болно. Автомат market making хийхийн тулд алгоритмууд нэмж болно. Мөн Market maker-үүдийг биржид татахын тулд хөнгөлөлт, мөнгөн урамшуулал өгч болно.




## Бусад нэмэлт функцууд

Түншлэлийн систем, техник шинжилгээний хэрэгслүүд бүхий мэргэжлийн график, автомат арилжаа, мэргэжилтний зөвлөгөө, арилжааны сэрэмжлүүлэг, back testing, социал медиагийн нэгтгэл, социал медиа мэдрэмжийн шинжилгээ, AI, сору арилжаа болон бусад функцууд.

## Тусламжийн хэсэг

Хэрэглэгчдэд туслах FreshDesk-ийн нэвтрүүлэлт.



## МУТСТ ТОГТОЛЦОО

Бид биржийнхээ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд эрсдэлийн үнэлгээ хийж, одоогийн төлөв байдлыг дүгнэж учирч болзошгүй эрсдэлийг болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон ажиллаж байна.

Эрсдэлийн түвшинг өндөр, дунд, бага эрсдэлтэй гэж ангилан тогтоож, эрсдэлээс үүсэх үр дагавар, ач холбогдлоос хамаарч авах урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.



**Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл**



**Бүтээгдэхүүн, үйлчилгээ болон технологиос хамаарч үүсэх эрсдэл**



**Газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэл**



# ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ



Тайлант хугацаанд бирж нь өөрийн системийн эх кодыг бүрэн эзэмшдэг давуу талаа ашиглан, үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш даруй шинэ хэрэглэгч татах, дотоодын төслүүдийг дэмжих, эдгээр виртуал хөрөнгийн арилжааны идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор арилжааны марафон, стэйкинг, арилжааны шимтгэл зэрэг урамшуулалт аян, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн бөгөөд биржийн хэрэглэгчдэдээ зориулж IOS, Android үйлдлийн системийг дэмжих мобайл аппликейшныг хэрэглээнд нэвтрүүлсэн билээ. Мөн оны эхний улиралд ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй биржүүдийн өнгөрсөн хугацааны арилжааны идэвх, харилцагчдын оролцоог судлан дотоодод арилжаалагдаж буй ТОП 8 Altcoin-г бирждээ амжилттай бүртгэл хийсэн ба дэлхийн 30 гаруй улсын 100 гаруй банк, брокер, эрсдэлээс хамгаалах сангуудын олон улсын жишигт нийцсэн Forex, Securities, Commodities арилжааны туршилтын горимыг нээгээд байв.




Түүнчлэн CPX токены хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор CPX токены анхдагч зах зээлийн арилжаанд оролцсон хөрөнгө оруулагчдад болон харилцагч нарыг санхүүгийн эрсдэлээс хамгаалах үүднээс Монголд анх удаа өөрийн гаргасан токеноо анхдагч зах зээлийн үнээр эргүүлэн татах ажлыг амжилттай хэрэгжүүлсэн. Өнгөрөгч оны III дугаар улиралд Capex биржийн удирдлага, бүтэц зохион байгуулалт шинэчлэгдэн санхүүгийн салбартаа туршлагатай, мэргэжлийн баг бүрэлдэхүүнийг бүрдүүлж хүний нөөцийн бодлого, түүний хэрэгжилтэд түлхүү анхаарал хандуулан ажиллаж байгаа бөгөөд биржийн зах зээлд эзлэх байр суурийг сайжруулах, үйл ажиллагааг тэлэх зорилгоор шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээний суурь болон судалгааг тогтмол хийж ажиллаа. Үүнтэй холбоотойгоор биржийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор бизнес төлөвлөгөөг мөн шинэчлэн ажиллаж байна.




Бид ISO/IEC 27001 олон улсын стандартын шалгуур үзүүлэлтийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж хэрэглэгчдийнхээ мэдээллийн аюулгүй байдлыг хуулийн дагуу бүрэн хамгаалахаас гадна, болзошгүй бусад эрсдэлээс хамгаалах удирдлагын болон үйл ажиллагааны тогтолцоо, стандарт горимуудыг бирждээ бүрэн нутагшууллаа. Удаах онцлох үйл явдал нь бирж оны эхнээс тасралтгүй 10 сарын турш нэгж CPX тутамд ₮0.01-өөр ногдол ашгийг хуваарилсан ба энэ нь тухайн үеийн нэгж CPX токены зах зээлийн үнэтэй харьцуулбал 50%, дунджаар 20%-ийн өгөөжийг ногдол ашиг хэлбэрээр токен эзэмшигчдэдээ олгосон. Бид тайлант жилийн эцэст нийгмийн хариуцлагын хүрээнд виртуал хөрөнгийн салбар дахь нийт хэрэглэгч, хөрөнгө оруулагч нарт тус салбарын суурь мэдлэгийг тогтмол, системтэйгээр хүргэх зорилгоор Capex Academy хөтөлбөрийг эхлүүлэн боловсролын контентыг бэлтгэн нийтэд үнэ төлбөргүй байдлаар түгээж эхлээд байгаа билээ.

# ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

## IEO буюу олон нийтээс босгосон хөрөнгийн зарцуулалт



## Үйл ажиллагааны орлого, хувьцаа эзэмшигчдийн санхүүжилтын зарцуулалт





# БИДНИЙ ЯЛГАРАЛ

2022 оны 2 сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн ВХҮҮ-ийн тухай хуультай холбоотойгоор биржийн гол цөм давуу тал, онцлог болсон крипто валютын арилжаанаас бусад форекс болон метал, түүхий эдийн биржийн үйл ажиллагааг Капекс Капитал ХХК бие даан явуулах боломжгүй нөхцөл байдалд хүрсэн. Гэсэн хэдий ч бид салбартаа эзлэх байр суурь, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, харилцагч нартаа амласан амлалт, биржийн хөгжлийн зураглалын дагуу виртуал хөрөнгийн чиглэлээр олон улсын стандарт, сайн туршлагад суурилсан илүү мэргэжлийн түвшний дараах шинэлэг үйлчилгээнүүдийг нэвтрүүлэхээр зорьж байна.

## 1 Виртуал хөрөнгө гаргагч нарын булан

Сарех биржид бүртгэлтэй дотоодын виртуал хөрөнгө гаргагч байгууллагууд манай вэбсайтад өөрсдийн үйл ажиллагааны тайлан, мэдээг олон нийтэд хүргэх, урамшуулалт хөтөлбөрүүдийг зарлах дэд цэстэй болно

## 2 Автомат хөрөнгө оруулалт



Хэрэглэгчдэд өөрт тохирсон багцыг бүрдүүлж сар бүр тогтмол дүнгээр хөрөнгө оруулалт хийх боломжтой болно

## 3 Хувьцаагаар баталгаажсан токен

Apple, Meta, Amazon зэрэг дэлхийн томоохон хувьцаат компанийн хувьцаагаар баталгаажсан токenuудыг биржид бүртгэж, хэрэглэгчдэдээ эрсдэл багатай токenuудыг арилжаалах боломж олгох

## 4 Сарех debt credit карт

Debt credit картын бүтээгдэхүүн нэвтрүүлэх



## 5 Зах зээлийн тойм

Крипто салбарын зах зээлийн голлох мэдээ, мэдээллийг цаг алдалгүй авч байх Market overview үйлчилгээ

## 6 Сарех академи

Крипто салбарын суурь мэдлэгийг тогтмол, системтэйгээр хүргэх Capex Academy хөтөлбөр

## 7 Токены тухай - дэлгэрэнгүй



Биржид арилжаалагдаж буй гадаад болон дотоодын виртуал хөрөнгүүдийн whitepaper, коммунити, токеномикс зэрэг дэлгэрэнгүй танилцуулгыг эх хэл дээрээ нэг дороос авах

## 8 Финтек зээлийн хөнгөлөлт

КҮС бүрэн хийгдсэн хэрэглэгчид, CPX токен эзэмшигчдэд хялбар, хурдан шуурхай финтек зээлийн үйлчилгээг хөнгөлөлттэй нөхцөлөөр авах боломжийг олгох

## 9 Тогтмол өгөөжтэй токен

Итгэлцлийн гэрээгээр баталгаажсан өндөр өгөөжтэй, анхны үнээр эргүүлэн татах нөхцөлтэй токеныг хэрэглэгч нартаа санал болгох





## 10 Stop limit функц

Зах зээлийн гэнэтийн, тааварлашгүй үйл явдлаас шалтгаалсан уналтын үед өөрийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хязгаарлах Stop limit функцийг хэрэглэгчдэд сурталчлан таниулж бодит хэрэглээнд нэвтрүүлэх

## 11 Whitelist

Хэрэглэгчид whitelist буюу зөвхөн баталгаажсан хаяг руу гүйлгээ хийх замаар хөрөнгөө алдах эрсдэлийг хязгаарлах

## 12 Найзаа урих


Referral буюу найзаа урих замаар арилжааны шимтгэлээс орлого олох боломж

## 13 Байгууллагаар бүртгүүлэх


Сарех биржид хуулийн этгээдээр данс нээх, харилцагчаар бүртгүүлэх үйлчилгээ

## 14 USDT-MNT арилжаа


Бирж дээр USDT-MNT хослолын хөрвөх чадварыг нэмэгдүүлж хамгийн бага шимтгэлээр ханшийн зөрүү багатайгаар арилжаалах боломжийг хэрэглэгч нартаа олгох



# ROADMAP







# ТОКЕНОМИКС

## Виртуал хөрөнгийн зорилго

Капекс биржийн үндсэн токен болох CPX нь харилцагчдадаа олон улсын болон дотоодын хөрөнгийн зах зээлд мэргэжлийн түвшинд нэг дор арилжаа хийх боломжийг олгож, эх орондоо валютын болон оюун санааны бодит хувь нэмэр оруулсан виртуал хөрөнгийн үйлчилгээг блокчэйн технологид нэвтрүүлж буй технологийн шийдэл бүхий виртуал хөрөнгө юм.

Токены нэр	CAPEX
Тикер	CPX
Блокчэйний төрөл	BEP-20
Сүлжээ	Binance Smart Chain
Нийт токены тоо ширхэг	200,000,000,000
Устгалд оруулах	100,000,000,000
Үүсгэн байгуулагч	30,000,000,000
Стратегийн хөрөнгө оруулагч	15,000,000,000
Олон нийтэд санал болгосон	15,742,395,992
Удирдлагын баг зөвлөхүүд	2,000,000,000
Тогтмол өгөөжтэй токен	4,000,000,000
Стэйкинг урамшууллын сан	10,000,000,000
Хөрвөх чадвар	3,000,000,000
Гадаад, дотоодын бирж дээр SEO	20,257,604,008



# CPX ТОКЕНЫГ ЭЗЭМШСЭНЭЭР ҮҮСЭХ ҮНЭ ЦЭНЭ

## 1 Ногдол ашиг

CPX токен эзэмшигчдэдээ биржийн үйл ажиллагааны ашгийн 30%-ийг ногдол орлогоор дамжуулж олгоно.



## 2 Лояалти

CPX токен эзэмшигчид уян хатан, хөнгөлттэй нөхцөлтэй санхүүгийн бүтээгдэхүүн авах боломжтой.



## 3 Хөнгөлөлт

CPX токен эзэмшигчид нь биржийн арилжааны шимтгэлээ үнийн дүнгээс хамааруулж үе шаттайгаар бууруулах боломжтой.



## 4 Урамшуулал


CPX Game хөгжөөнт тоглоомд оролцон урамшуулал авах боломжтой.

## 5 Стэйкинг

CPX стэйкинг үйлчилгээнд хамрагдан жилийн +20% токены өгөөж авах боломжтой.



# БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





## МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Хүний нөөцийн бодлого зорилго
2. Биржийн ёс зүйн хэм хэмжээ
3. Биржийн ил тод байдал



### ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ЗОРИЛТ

Байгууллагын үндсэн хэсэг нь барилга байшин, бодлого, дүрэм журам тогтоохдоо бус хүмүүс хоорондын харилцаа гол үүрэг гүйцэтгэж байдаг. Аливаа байгууллагын амжилтын үндэс нь чадварлаг хүний нөөцтэй байхад оршино. Нөгөө талаас хичнээн ур чадвар өндөр хүний нөөцтэй байсан ч удирдлагын бодлого, шийдвэр сул байх тусам авьяас чадвартай ажилтнуудын ур чадвар суларч эхэлдэг. Иймээс хүний нөөцийн менежментийн оновчтой бодлого чухал.



### ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ


Компанийн ил тод нээлттэй байдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллах ба нөхцөл шаардлагыг хэрэгжүүлэн компанийн цахим хуудас болон холбогдох цахим вэб сайтад байршуулна. Шаардлагатай тохиолдолд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах, нийтэд түгээх ажлыг хэрэгжүүлж болно.



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Капекс виртуал хөрөнгийн биржийн хувьцааг 1 хүн, 1 хуулийн этгээд тус тус эзэмшиж байна.

Капекс  
Капитал ХХК



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийг үр ашигтай ажиллах шийдвэр гаргах, компанийн үйл ажиллагааг хянах, стратегийг тодорхойлж ажилладаг болно. ТУЗ-ийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан бөгөөд тухайн үйл ажиллагааг зохицуулсан журамтай байна. ТУЗ-ийн дэргэд Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Эрсдэлийн удирдлага, комплаенсын хороо, Дотоод аудитор тус тус ажилладаг бөгөөд хурлаар орох асуудлыг урьдчилан хянаж зөвлөлдөж, ТУЗ-д зөвлөмж хүргүүлэн үйл ажиллагааг дэмжин ажилладаг билээ.

Компанийн ТУЗ нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж үүнээс 2 нь хараат бус гишүүдээс бүрдэж байна. Гишүүд нь банк, даатгал, үнэт цаас зэрэг санхүүгийн салбарт ажиллаж байсан арвин туршлага, өндөр ур чадвартай болно.





(+976) 75077272



info@capexcapital.mn



capex.mn



Монгол улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,  
Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал  
Тауэр, 7 давхар, 707 тоот